БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2024/110/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг:<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>“Ужим Алтай Аудит” ХХК-ны захирал: Б.Галымбек<br>Утас: 99101563 Цахим хаяг: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 11
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 14
4.1 Ерөнхий зүйл ........ 14
4.2 Материаллаг байдал ........ 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 15
5.1 Төлбөрийн акт ........ 15
5.2 Албан шаардлага ........ 15
5.3 Зөвлөмж ........ 15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЁЛТ
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ К.ЗЕРДЕГУЛ
ТАНАА

2024.02.23 № 304
танай ____________-ны № ____________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402373

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,958,703.47** | **77,143,316.97** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 10,428,893.37 | 60,823,816.17 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 10,428,893.37 | 60,823,816.17 |
| **3121** | **Төгрөг** | 10,428,893.37 | 60,823,816.17 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,325,393.37 | 60,823,816.17 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 103,500.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 23,529,810.10 | 16,319,500.80 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,529,810.10 | 16,319,500.80 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 192,000.00 | 154,380.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,768,932.00 | 7,799,332.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 660,100.00 | 1,390,680.00 |
| 35460 | Хүнсний материал | 12,789,878.10 | 6,856,208.80 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 118,900.00 | 118,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **581,160,656.09** | **578,608,049.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 581,160,656.09 | 578,608,049.69 |
| **392** | **Биет хөрөнгө** | 576,160,656.09 | 573,608,049.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 17,013,723.30 | 17,013,723.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,944,425.76) | (2,430,532.20) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 8,632,500.00 | 8,632,500.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (2,367,141.57) | (3,515,641.53) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5,591,620.00 | 5,591,620.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (765,619.88) | (1,683,619.88) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 550,000,000.00 | 550,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **615,119,359.56** | **655,751,366.66** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **615,119,359.56** | **655,751,366.66** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 615,119,359.56 | 655,751,366.66 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,933,080.00 | 5,933,080.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 5,933,080.00 | 5,933,080.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 609,186,279.56 | 649,818,286.66 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 609,186,279.56 | 609,186,279.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 40,632,007.10 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **615,119,359.56** | **655,751,366.66** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **160,388,400.00** | **269,630,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **160,388,400.00** | **269,630,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 137,344,810.00 | 257,108,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 137,344,810.00 | 257,108,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,043,590.00 | 12,522,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,043,590.00 | 12,522,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **111,976,275.74** | **228,998,392.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **111,976,275.74** | **228,998,392.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 111,976,275.74 | 228,997,518.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 81,024,120.00 | 169,171,163.62 |
| 210101 | Үндсэн цалин | 74,646,861.00 | 108,744,393.31 |
| 210102 | Нэмэгдэл | 4,939,315.00 | 52,112,923.05 |
| 210104 | Урамшуулал | 1,437,944.00 | 8,313,847.26 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11,444,446.00 | 17,114,183.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,127,560.46 | 12,734,483.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,105,938.67 | 1,095,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 856,422.33 | 876,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 213,467.20 | 218,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,141,057.34 | 2,189,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6,997,185.00 | 10,190,046.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 356,185.00 | 748,526.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,641,000.00 | 9,441,520.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 66,000.00 | 693,680.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 66,000.00 | 126,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 489,880.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 77,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,439,946.47 | 17,887,719.30 |
| 210502 | Хоол, хүнс | 6,439,946.47 | 17,887,719.30 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 80,000.00 | 4,869,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 42,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 80,000.00 | 4,827,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 124,000.00 | 194,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 124,000.00 | 194,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,800,578.27 | 8,877,726.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,993,602.00 | 5,323,220.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,487,900.00 | 1,001,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,319,076.27 | 2,552,606.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 874.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 874.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 874.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **48,412,124.26** | **40,632,007.10** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **48,412,124.26** | **40,632,007.10** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **195,068,300.00** | **269,630,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **195,068,300.00** | **269,630,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 169,714,010.00 | 257,108,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 169,714,010.00 | 257,108,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,500.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,500.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25,250,790.00 | 12,522,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,250,790.00 | 12,522,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **184,639,406.63** | **219,235,477.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **184,639,406.63** | **219,235,477.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **184,076,957.63** | **219,234,603.20** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 129,120,738.63 | 169,148,663.62 |
| 210101 | Үндсэн цалин | 99,771,652.14 | 108,721,893.31 |
| 210102 | Нэмэгдэл | 23,355,064.00 | 52,709,198.90 |
| 210104 | Урамшуулал | 5,311,981.49 | 7,717,571.41 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 682,041.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,897,300.00 | 17,114,183.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,170,300.00 | 12,734,483.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,431,900.00 | 1,095,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,145,400.00 | 876,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 286,300.00 | 218,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,863,400.00 | 2,189,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,500,400.00 | 12,221,526.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,588,400.00 | 2,237,526.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,912,000.00 | 9,984,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 103,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 103,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 20,633,900.00 | 12,031,850.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,633,900.00 | 12,031,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 300,000.00 | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 296,000.00 | 471,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 296,000.00 | 471,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,328,619.00 | 7,843,880.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,328,619.00 | 6,430,180.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 1,413,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **562,449.00** | **874.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 562,449.00 | 874.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 562,449.00 | 874.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,428,893.37** | **50,394,922.80** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 10,428,893.37 | 50,394,922.80 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 10,428,893.37 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 10,428,893.37 | 60,823,816.17 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 0.00 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,933,080.00** | **609,186,279.56** | 615,119,359.56 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | 0.00 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,933,080.00** | **609,186,279.56** | 615,119,359.56 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | 40,632,007.10 | 40,632,007.10 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,933,080.00** | **649,818,286.66** | 655,751,366.66 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 279,955,793.37 | 219,131,103.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 279,955,793.37 | 219,131,103.20 |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 279,955,793.37 | 219,131,103.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 215,957,300.00 | 169,148,663.62 |
| 210101 | Үндсэн цалин | 138,154,600.00 | 108,721,893.31 |
| 210102 | Нэмэгдэл | 68,797,900.00 | 52,709,198.90 |
| 210104 | Урамшуулал | 9,004,800.00 | 7,717,571.41 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,863,700.00 | 17,114,183.58 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,947,500.00 | 12,734,483.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,229,100.00 | 1,095,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,783,500.00 | 876,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 445,600.00 | 218,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,458,000.00 | 2,189,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,222,400.00 | 12,221,526.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,238,400.00 | 2,237,526.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,984,000.00 | 9,984,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 15,297,300.00 | 12,031,850.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,297,300.00 | 12,031,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 300,000.00 | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 471,200.00 | 471,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 471,200.00 | 471,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,843,893.37 | 7,843,880.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,430,193.37 | 6,430,180.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,413,700.00 | 1,413,700.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 269,630,400.00 | 269,629,526.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 257,108,000.00 | 257,108,000.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 257,108,000.00 | 257,108,000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 12,522,400.00 | 12,521,526.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 12,522,400.00 | 12,521,526.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 10,325,393.37 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 10,325,393.37 | 60,823,816.17 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 12 | 12 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 4 | 4 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2 | 2 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **12** | **12** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 5 | 5 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5 | 5 |
| 650010 | Гэрээт ажилтан | 2 | 2 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **103500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **103500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 103500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 103500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 103500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 103500.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Аймгийн боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн зорилтыг үндэслэн хүүхэд бүр сурч хөгжих таатай орчин бүрдүүлэх зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

- Цэцэрлэгийн үйл ажиллагааг журмын дагуу төлөвлөж ажиллах;
- Багш, ажилтанд стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлэх;
- Цэцэрлэгийн үйл ажиллагааг хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай суралцах, хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөлт ажил, арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах, хамтын ажиллагаа, түншлэлийг идэвхжүүлэх;
- Цэцэрлэгийн эрхлэгч, багш, туслах багшийг чадваржуулах, монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангана;
- Удирдах ажилтан, багш, туслах багш, ажилтан бүр ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөнө;
- Хамран сургах тойргийн 2-5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамрагдах боломж олгох;
- Цэцэрлэгийн ариун цэвэрт анхаарч, хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдал, шим тэжээл, чанарыг сайжруулах.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн

зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй ба тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг нь нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40.6 сая төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10,428.89 | 60,823.82 | 50,394.92 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 23,529.81 | 16,319.50 | -7,210.31 |
| Үндсэн хөрөнгө | 581,160.66 | 578,608.05 | -2,552.61 |
| **Нийт хөрөнгө** | **615,119.36** | **655,751.37** | **40,632.01** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 615,119.36 | 655,751.37 | 40,632.01 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **615,119.36** | **655,751.37** | **40,632.01** |

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 60.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын данс 7.2 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 28.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 33.4 сая төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 2.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд орлого ба зарлагын гүйлгээ хийгдээгүй, элэгдлийн зардлын хэмжээгээр зөрүүтэй байна.

Тайлант онд 40.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 191.0 сая, орон нутгийн төсвөөс 12.5 сая, нийт 203.5 сая, нийт зарлагыг 203.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 63.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, баталсан байна. Энэ нь 2023 онд төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой дээд шатны төсвийн захирагч хуваарьт өөрчлөлт оруулж нэмэгдүүлж өгсөнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 279.9 сая төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 257.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 12.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10.3 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс зарцуулахаар тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 257.1 сая , орон нутгийн төсвөөс 12.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 219.1 сая төгрөг буюу 78.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 60.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр | | | | |
| 1 | Эрүүл мэндийн дэмжих | 706.90 | 706.90 | 0.00 | 100.00% |
| 2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 15,297.30 | 12,031.85 | -3,265.45 | 78.65% |
| 3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 1,411.40 | 1,411.40 | 0.00 | 100.00% |
| 4 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 706.90 | 706.90 | 0.00 | 100.00% |
| 5 | Боловсролын стандарт, сургалт | 150,563.20 | 106,809.95 | -43,753.25 | 70.94% |
| 6 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 98,747.70 | 84,942.58 | -13,805.12 | 86.02% |
| 7 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 12,522.40 | 12,521.53 | -0.87 | 99.99% |
| | **Дүн** | **279,955.80** | **219,131.10** | **-60,824.70** | **78.27** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.43 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Ёлт цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Булган сумын Ёлт цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 28.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах  үндсэн үйл ажиллагаа болон шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ужим Алтай аудит” ХХК-ны захирал бөгөөд аудитор Б.Галымбек гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек , дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ужим Алтай Аудит “ХХК-нд 2023  оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн  нийт зардал 187.2 сая төгрөгийн 2 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 46.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10.7 сая, нормативт зардлыг 3.2 сая, 60.8 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд цалингийн зардлаас бусад  5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын болон зарлагын мөнгөн гүйлгээ байхгүй, төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр гараагүй, тайлант онд өр, авлага үүсгэж ажиллаагүй байгаа тул оруулах мэдээлэл байхгүй байна. Тайлант хугацаанд оруулах шаардлагатай төсөвтэй  холбоотой бусад мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил илрээгүй.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар  алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг болон нярвын тайланг дэлгэрэнгүй шалгах, эд хөрөнгийн тооллогыг үзэх шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд алдаа[1] илрээгүй, залруулга хийгдээгүй.

Аудитаар зөрчил[2] илрээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |